

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709  
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ  
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.15

### Онцлох мэдээ

- Дэлхийн 3-р том эдийн засаг болох Японы ДНБ 2021 оны 3-р улиралд 2.7% агшаад байсан бол 4-р улиралд 5.4% тэлжээ. Коронавирусын тохиолдлууд буурсан нь хэрэглээг нэмэгдүүлж үүнд нөлөөлсөн бол түүхий эд материалын үнийн өсөлт, шинэ Омикрон хувилбарын халдвар цаашдын төлөвийг бүрхэг болгосоор байна.
- Дэлхийн худалдааны гацаа нийлүүлэлтийн гинжин хэлхээний саатлаас илүүтэй эрэлтийн өсөлтийн үр дүнд бий болоод байгаа ба ирэх саруудад дарамт буурах магадлалтай гэж Дэлхийн худалдааны байгууллагын ахлах эдийн засагч хэлжээ.

### Валютын зах зээл

Зүүн Европ дахь хурцадмал байдал еврогийн ханшинд дарамт учруулж, ам.доллар болон эрсдэл багатай иений эрэлт нэмэгдээд байна. Мөн ам.долларын ханшинд АНУ бодлогын хүүгээ илүү эрчтэй өсгөж магадгүй гэсэн мэтгэлцээн дэмжлэг үзүүлэв. Азийн нээлтийн арилжаагаар евро 1.1308 хүрч өмнөх өдрийн 1.1278-с өндийсөн байна. Иен өчигдөр цухасхан 114.99 хүрсний дараа өнөөдөр 115.33-тэй тэнцүү байна. Оросын рубль хэлбэлзэл өндөртэй хэвээр байсан ч Даваа гарагт 1.1% чангарсан бол өнөөдрийн Азийн арилжааг сулхан эхлүүллээ. Нэг долоо хоногийн доод түвшин 1.3495-т очоод байсан фунт өчигдөр ам.долларын эсрэг 1.3512 буюу 0.4% доогуур арилжаалагджээ.

### Алтны зах зээл

Мягмар гарагт алтны ханш өсөж өмнөх арилжааны өдөр хүрсэн 3 сарын хугацааны дээд цэг рүү дөхөж байна. Украйны талаар Орос болон Барууны хоорондох маш хурцадмал байдал хөрөнгө оруулагчдыг эрсдэлтэй хэрэгслээс татгалзаж эрсдэлгүй гулдмайг сонгоход хүргээд байгаа юм. Өглөөний байдлаар унц алтны спот 0.1% өсөлттэй 1,871.52 ам.доллар байлаа. Харин АНУ-ын алтны фьючерс 0.2% өсөлттэй 1,873.40 ам.доллар хүрээд байна.

### Зэсийн зах зээл

Украйны хилийн ойролцоох хурцадмал байдал хөрөнгө оруулагчдыг эрсдэлтэй хөрөнгийн худалдан авалтаа багасгахад хүргэснээр зэсийн ханш өнөөдөр буурлаа. Гэхдээ Орос улсад хориг тавьж магадгүй аюул нь хөнгөн цагаан, никелийн үнийг өсгөсөн байна. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс 0.1% унаж 9,911 ам.доллараар арилжаалагдаж байгаа бол Шанхайн Фьючерсийн Бирж дээрх зэсийн гэрээ 0.2% суларч 71,110 юань (\$11,195.78) боллоо.

### Газрын тосны зах зээл

Хөрөнгө оруулагчид өсөлтөөс ашгаа авч эхэлснээр

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.1312	0.04%		
USD/CNY	6.3559	0.07%		
USD/RUB	76.7663	0.01%		
USD/JPY	115.34	-0.17%		
USD/KRW	1198.15	0.37%		
AUD/USD	0.7124	-0.01%		
GBP/USD	1.3538	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	34566.2	-0.49%		
S&P 500	4401.7	-0.38%		
NASDAQ	13790.9	0.00%		
FTSE 100	7531.6	-1.69%		
Nikkei 225	27038.8	-0.15%		
DAX	15114.0	-2.02%		
Hang Seng	24458.5	-0.40%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1871.18	0.00%		
Мөнгө	23.87	0.12%		
Нүүрс (Чин хуанг дао)	165.99	0.00%		
Зэс (LME)	9920	0.60%		
Төмрийн хүдэр	737.00	-5.09%		
Газрын тос (NYME)	94.89	-0.60%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.19%	54.51%		
US 3M LIBOR	0.51%	28.26%		
US 6M LIBOR	0.84%	26.49%		
US 12M LIBOR	1.39%	23.81%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.97%	-0.88%		
UK Treasury 10Y	1.59%	2.85%		
GE Treasury 10Y	0.28%	-4.71%		
JP Treasury 10Y	0.22%	-1.38%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.10%	0.05%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.46%	0.00%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.28%	-0.01%
Хуралдай	8.75%	3/9/2024	4.07%	-0.08%
ММС	9.25%	4/15/2024	22.95%	0.78%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.22%	-0.06%
Номад	5.13%	4/7/2026	4.75%	-0.08%
Монгол 27	3.50%	7/7/2027	5.01%	-0.12%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.41%	-0.01%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.03%	-0.01%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	20.45	-0.29%
Mongolian Mining Corp	2	-2.44%
Erdene Resource Dev	0.44	2.35%
Centerra Gold	10.88	0.28%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2021 (XII)	13.4%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XI)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (XII)	7.04%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (XII)	2.04%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (XII)	15.54%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (XII)	9.07%

#### Ханшийн таамаглал

Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.15	1.17
GBP/USD	1.34	1.35	1.36	1.37	1.40
USD/CNH	6.39	6.35	6.40	6.44	6.40
USD/JPY	114	115	115	115	115
USD/RUB	73.0	72.0	73.07	73.0	73.5

#### Түүхий эд

Алт	1775	1750	1700	1680	1650
Зэс	9500	9350	9400	9500	9550
Нүүрс	138.13	109.38	93.13	79.38	62.50

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

#### Өмнөх өдрийн үр дүн

	Үр дүн	Таам.	Өмнөх
-	-	-	-

#### Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ

	Цаг	Таам.	Өмнөх
GE ZEW Current Conditions	18:00	-7.0	-10.2
GE ZEW Economic Sentiment	18:00	53.5	51.7
UK ILO Unemployment Rate	15:00	4.1%	4.1%
JP GDP QQ Annualized	7:50	5.8%	-3.6%
JP GDP QQ	7:50	1.4%	-0.9%

#### Маргааш хүлээгдэж буй мэдээ

	Цаг	Таам.	Өмнөх
US Retail Sales MM	21:30	2.0%	-1.9%
US Industrial Production MM	22:15	0.4%	-0.1%
UK CPI YY	15:00	5.4%	5.4%
CN CPI YY	9:30	1.0%	1.5%
CN PPI YY	9:30	9.5%	10.3%

#### Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мэйлд харуу илгээнэ үү.